



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/39/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ  
ТАНАА

2018.02.23 № 06/480  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ахмад настны үндэсний төвийн ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ахмад настны үндэсний төвийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.





## Аудитын гол асуудал


Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалтын дагуу Ахмадын үндэсний төвд үйлчлүүлэгчдийн 2017 оны тэтгэврийн 30 хувийн орлогын үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийн орлогыг Төрийн сангийн харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулсан нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын 2 дугаар зүйлийн 6 дугаар заалт "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана." заалтыг зөрчсөн байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй  
тайлан бэлтгэх загвар

Огноо: 2018-02-20

Нэг. Ерөнхий мэдээлэл

|                                   |   |                                      |   |
|-----------------------------------|---|--------------------------------------|---|
| Аудитын код:                      | САГ-2018/39/САГ-ТШЗ   | Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: | Ахмадын үндэсний төв  |
| Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: | “Нийслэл-Аудит” ХХК   | Аудит хийсэн баг, албан тушаалтан    | Аудитор Л.Сарантуяа аудитын шинжээч Д.Борчулуун, аудиторын туслах Д.Доржпүрэв |
| Аудитын нэр:                      | Ахмад настны үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит |                                      |   |

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |         |                |                 | Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                           |
|---|---|--------------------------|-----------------------------|---------|----------------|-----------------|----------------------------------|----------------|-------|---------------------------|
|   |   | Аудит хамрагдах          | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |         |                |                 | Зөрчилгүй                        | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс тагталсан |
|   |   |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт | Итгэл үзүүлсэн | Аудит хийгээгүй |                                  |                |       |                           |
| A | 1   | 2                        | 3                           | 4       | 5              | 6               | 7                                | 8              | 9     | 10                        |
| 1 | Ахмад настны үндэсний төв                   | 1                        | 1                           |         |                |                 |                                  | 1              |       |                           |
| 2 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
| 3 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
| 4 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
| 5 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
| 6 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
| 7 |   |                          |                             |         |                |                 |                                  |                |       |                           |
|   | ДҮН   | 1                        | 1                           |         |                |                 |                                  | 1              |       |                           |

**01** ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



## Хоёр. Аудитын үр дүн

### 2.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн |           | Үүнээс    |               |                 |  |
|---|-------------------------------------|-----------------|-----------|-----------|---------------|-----------------|--|
|   |                                     | Тоо             | Дүн       | Зөвлөмж   | Төлбөрийн акт | Албан шаардлага | Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн |
| A | 1                                   | 2               | 3         | 4         | 5             | 6               | 7  |
| 1 | Ахмад настны үндэсний төв           | 2               | 117,472.8 | 117,472.8 |               |                 |  |
| 2 |                                     |                 |           |           |               |                 |  |
| 3 |                                     |                 |           |           |               |                 |  |
| 4 |                                     |                 |           |           |               |                 |  |
| 5 |                                     |                 |           |           |               |                 |  |
| 6 |                                     |                 |           |           |               |                 |  |
|   | ДҮН                                 | 2               | 117,472.8 | 117,472.8 |               |                 |  |

### 2.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

#### Алдаа, зөрчилтэй асуудал 1

Халамжийн хуулийн дагуу Ахмадын үндэсний төвд үйлчлүүлэгчдийн 2017 оны тэтгэврийн 30 хувийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийн орлогыг Төрийн санд тушаалгүй касст бэлнээр үлдээсэн

#### Шийдвэрлэсэн нь:

Тэтгэврийн 30 хувийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл 53,5314.6 мянган төгрөгийг байгууллагын Төрийн сангийн харилцах дансанд 2018 оны 3 сарын 5 ны дотор тушаах, 2018 оны тэтгэврийн орлогын 30 хувийн зарцуулалтыг төсвийн төлөвлөгөөнд тусгуулах асуудлыг шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгсөн.

#### Алдаа, зөрчилтэй асуудал 2

Хангамжийн бараа материалын худалдан авалтыг данс бүртгэлд тусгахдаа мөнгөн хөрөнгийн дансыг шууд зардлын данстай харьцуулж алдаатай бүртгэл хөтөлдгөөс 35,194.6 мянган төгрөгийн бараа материалыг илүү зарлагдсан. Хандиваар үнэгүй хүлээж авсан 28,743,6 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй

#### Шийдвэрлэсэн нь:

Бараа материалын худалдан авалтыг тооцооны дансаар данжуулан аудитын тайлбар бүтгэж анхан шатны баримтыг үндэслэн зардлын гүйлгээг хийж байх зөвлөмж өгч 63838,2 мянган төгрөгөөр санхүүгийн тайланг залруулав.

01

ХЯРГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 2.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Ахмад настны үндэсний төвд үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 2017 оны 30 хувийн орлогын үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийн орлогыг харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулсан нь материаллаг хэмжээтэй бөгөөд залруулах боломжгүй тул Хязгаарлалттай дүгнэлт өгөгдсөн

#### Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Албан тушаал овог нэр:

Нийслэл-АудитХХК Ахлах аудитор : *Л.Сарантуяа* Л.Сарантуяа

Анхан шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:

Нийслэл-Аудит ХХК Аудитор *Б.Өлзийзаяа* Б.Өлзийзаяа

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:

Нийслэл-Аудит ХХК Захирал *Т.Сугарсүрэн* Т.Сугарсүрэн

Танилцаж зөвшөөрсөн:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ





# АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний аудитын газрын санхүүгийн  
аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261885  
Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Жавхлан  
Утас: 261628  
Цахим хаяг: [javkhlant@audit.gov.mn](mailto:javkhlant@audit.gov.mn)

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4-р байр, бага тойруу – 3  
Чингэлтэй дүүрэг  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
“Нийслэл-Аудит” ХХК  
Утас: 70110095

Web: [www.niislelaudit.mn](http://www.niislelaudit.mn)

Захирал: Т.Сугарсүрэн  
Утас: 99115395

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Санхүүгийн тайлангийн аудитын  
хураангуй.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийнэ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ахмад настны үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Ахмад настны үндэсний төвийн 2017 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 14-ний хооронд хийхээр төлөвлөсөн боловч санхүүгийн тайлангийн залруулгын дүн өндөр байсантай холбоотойгоор аудитын хугацаанд санхүүгийн тайланг шинээр хийж баталгаажуулахад төлөвлөснөөс илүү хугацаа зарцуулсан болно. Санхүүгийн тайлангийн аудитыг “Нийслэл-Аудит” ХХК-ийн аудитор Т.Сугарсүрэн шинжээч Д.Борчулуун, аудиторын туслах Ц.Даваажав нар хэрэгжүүлэн ахлах аудитор Л.Сарантуяа, чанарын хяналтыг хийв. /ТАБ-СТА-А-9/

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Ахмад настны үндэсний төвийн төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоол шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-тай нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх зорилготой байв.





### Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус байгууллага нь үйлчлүүлэгчдийн эрхийг хүндлэн дээдэлж, сэргээн засах эмчилгээ сувилгаа үзүүлэх тодорхой хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах, хөгжүүлэх, цаашид бие даан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангахад оршиж байна.

Зорилт:

Үйлчлүүлэгчдийг эрүүл аюулгүй, таатай орчинд амьдруулах, үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хувцас, эм тариа, ахуйн хэрэгслэлээр хангана.

Үйлчлүүлэгч бүрийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хөгжил, хамгааллын шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэх.

Үйлчлүүлэгч бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ асаргаа сувилгааг үзүүлэх.

Үйлчилгээ нь хүнд сурталгүй, авилгаас ангид, ашиг сонирхолын зөрчилгүй байх. Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Нийгмийн Халамжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.


Аудитаар Ахмад настны үндэсний төвийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Ахмад настны үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/ Харин тус байгууллага Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Аcolous санхүүгийн програмыг иж бүрнээр нь ашигладаггүй зөвхөн бараа материалын орлого зарлагыг гүйцэтгэж байсан бөгөөд аудитын явцад тус програмыг иж бүрнээр нь ашиглалтанд оруулж залруулсан санхүүгийн тайланг программаар дахин гаргасан болно.

### Материаллаг байдлын түвшин:

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төвийн аудитын байгууллага төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн "Санхүүгийн үр дүнгийн тайлан" дах нийт зардал 2,131,615.1 мянган төгрөгийн хувцаа тооцож зөвхөн 21,316.1 мянган төгрөг болж байна.





### Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ахмад настны үндэсний төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна.

### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Ахмад настны үндэсний төвийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,672,763.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Тус төв нь ахмадын сувиллын үйлчилгээнээс 209,806.5 мянган төгрөг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалт буюу “Төрөлжсөн асрамжийн хүрээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэвэрийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмийн дагуу олгоно” гэсний дагуу үйлчлүүлэгч ахмадуудын тэтгэврийн 30 хувийн 2016 оны үлдэгдэл, 2017 оны орлого бүгд 143,209.7 мянган төг, бусад орлого 750.0 мянган төгрөг хандивын орлого 501,244.6 мянган төгрөгийн орлого нийт улсын төсвөөс гадна 855,010.8 мянган төгрөгийн орлого олж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулсан талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр нь байршуулсан байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэл гарах эрсдэлийг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал зэрэг дансанд тооцож үзэв.

Тохиолдох магадлалтай уламжлалт эрсдэлүүдээс дээрх дансууд уламжлалт эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж тооцов. /Маягт ТАБ-СТА-5-1/

Санхүүгийн тайлан дахь материаллаг буруу илэрхийллийг дотоод хяналтаар цаг тухайд нь илрүүлээгүй, засварлаагүй байх эрсдэлийг тооцож үзэв.

### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Ахмад настны үндэсний төвийн 2017 оны хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц





хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, туслах аж ахуй, хандивын орлого, хүнс болон эмийн зардал, бусад зардлууд болох бичиг хэрэг, шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 117,472.8 мянган төгрөгийн дараахь алдаа зөрчлүүд илэрсэн болно.

***Асуудал №1 Халамжийн хуулиар олгогдож буй тэтгэврийн орлогын бүртгэлийн талаар***

Нийгмийн халамжийн тухай хуулийн 2013 онд шинээр нэмэгдсэн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалт: “Төрөлжсөн асрамжийн хүрээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэвэрийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад ...олгоно” гэсний дагуу 2013 оны 3 дугаар сараас хойш тус Ахмадын үндэсний төвийн үйлчлүүлэгч нарын тэтгэврийн 30 хувийг бэлнээр кассет хүлээн авч зарцуулж эхэлсэн байна. Энэхүү орлогыг 2016 оны эцэс хүртэл санхүүгийн тайлангийн балансаас гадуур бүртгэж ирсэн байна. 2016 оны 12 сарын 31 ний байдлаар тэтгэврийн орлогын касс нь 37,957,7 мян төгрөгийн үлдэгдэлтэй үлдсэн бөгөөд 2017 онд шинээр 105,251,9 мян. төгрөгийн орлого нэмэгдэж 89,675,0 мян төгрөгийн зарцуулалт гарсан байна. 2017 оны санхүүгийн тайланд 2016 оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл болон 2017 оны орлого зарлагыг санхүүгийн нэмэлт санхүүжилтын орлого зарлагаар бүртгэсэн боловч төвлөрсөн төсвийн зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4: “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байна” заалт зөрчигдсөн байна.

2017 оны жилийн эцэст тэтгэврийн 30 хувийн орлого 53,534,6 мянган төгрөг бэлнээр кассет үлдсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21 ний өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын 2 дугаар зүйлийн 6 дугаар заалт ” *Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.*”-ыг зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь:** Үйлчлүүлэгчдийн зарцуулагдаагүй тэтгэврийн орлогын 30 хувийн 2018 оны 2 сарын 28 ны кассет байгаа үлдэгдэл 64,000.0 мянган төгрөгийг байгууллагын Төрийн сангийн харилцах дансанд тушаалгаж, Үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн нэмэлт санхүүжилтийн орлого зардлыг албан ёсоор төсвийн төлөвлөгөөнд суулгуулж батлуулах асуудлыг дээд төрийн аудитын байгууллага шийдвэрлүүлэх талаар зөвлөмж, албан шаардлага хүргүүлэв.

**Асуудал №2 Бараа материалын бүртгэлийн талаар**

01

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



Ахмад настны үндэсний төв нь өдөр тутмын байнга хэрэглэгддэг хүнс, эм, нүүрс зэрэг зарим хангамжийн материалын худалдан авалтыг данс бүртгэлд тусгалгүйгээр шууд зарцуулснаар буюу мөнгөн хөрөнгийн дансыг шууд зардлын данстай харьцуулж ерөнхий журналд бичилт хийж байна. Ялангуяа уурын зуухны нүүрсний зарцуулалтанд бүртгэлээр хяналт тавьдаггүй, хэмжих боломжгүй гэсэн шалтгаанаар хүлээн авсан бүх нүүрсийг зарцуулснаар тайлагнаж байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн энэхүү буруу бичилтээс шалтгаалан бараа материалын агуулахын эцсийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, тайлант үеийн нийт бараа материалын зардал 35,194.6 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд илүү тусгагдсан байна. Мөн үнэ төлбөргүй хүлээж авсан 28,743.6 мянган төгрөгийн бараа материалын орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй, өөрийн туслах аж ахуйгаас хүлээж авсан хүнсний ногоог бүртгэлд бүрэн тусгахгүй зөвхөн зарцуулсан хэмжээгээр нь орлого зарлагаар бүртгэж байгаагаас туслах аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүний бүртгэлд хяналт тавих боломжгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв

**Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад 63,938.2 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн алдааг залруулж санхүүгийн тайланг шинээр дахин гаргасан тул залруулагдаагүй материаллаг бус дүнтэй алдаа байхгүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Ахмад настны үндэсний төвийн үйлчлүүлэгчдийн гал тогоонд бэлтгэж байгаа хоолны материалын зарцуулалтыг технологийн картаар тооцолгүй, нэг үйлчлүүлэгчид оногдох зардлаар нормчлон тооцож байгаа нь бодит зарцуулалтаас зөрүүтэй байх эрсдэлтэй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний болон эмийн хангамж түүний зарцуулалтыг нарийвчлан үзэх болно. Энэ нь 2017 оны аудитын хүрээнд хийгдэх ёстой ажил боловч цаг хугацааны хязгаарлалттай нөхцлийн улмаас нарийвчлан тулган баталгаажуулалт хийх боломжгүй байсан болно. Мөн түүнчлэн үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн орлого зардлыг төсвийн төлөвлөгөөнд тусгуулах асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг шалгаж үзэх болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Аудитаар нийт 117,472.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 63,938.2 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан бөгөөд Төрийн сангийн харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулсан үйлчлүүлэгчдийн тэтгэврийн орлогын 30 хувийн үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийн зөрчил нь залруулах боломжгүй байна.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Ахмад настны үндэсний төвийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд “Юнистар Аудит” ХХК аудит хийж аудитаар 3 зөвлөмж өгсний 2 нь хэрэгжсэн, 3 дахь зөвлөмж буюу “Бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оныхоос 224,624.8 мянган

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгөөр өссөн байгааг хэрэгцээт хэмжээнд байлгах” зөвлөмжийн хувьд тайлант оны бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс дахин 199,322.4 мянган төгрөгөөр өссөн нь шинээр ахмадын сувиллын төв нээгдэж ашиглалтанд орсонтой холбоотойгоор хангамжийн болон хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлт:**


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ахмад настны үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон хавсралтууд 27 хуудас хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

“Нийслэл-Аудит” ХХК-ийн захирал



Т.Сугарсүрэн

**БЭЛТГЭСЭН:**

Ахлах аудитор  
Шинжээч



Л.Сарантуяа  
Д.Борчулуун

2017.02.23

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

*Асуудал 1*

Үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн орлогын  
бүртгэлийн талаар

*Асуудал 2*

Бараа материалын бүртгэлийн талаар

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## Менежментийн захидал

“Нийслэл-Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Ахмад настны үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Нийслэл-Аудит” ХХК –ийн энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Ахмад настны үндэсний төвийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



“Нийслэл-Аудит” ХХК-ийн ажиглалт

а/ Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалтын дагуу Ахмад настны үндэсний төвд үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн орлогыг хууль батлагдсан өдрөөс хойш буюу 2013 оноос хойш хүлээн авч журмын дагуу зарцуулж байгаа боловч улсын төсвийн орлого зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 2 дугаар заалт: *“Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.”* 6 дугаар зүйлийн 6.3.4: *“төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байна”* гэснийг тус тус зөрчсөн байна.

б/ Бэлнээр хураан авч байгаа тэтгэврийн 30 хувийн орлогын 2017 оны жилийн эцсийн зарцуулагдаагүй үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийг Төрийн сан банкинд тушаалгүй бэлнээр кассет үлдээсэн нь Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21 ний өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын 2 дугаар зүйлийн 6 дугаар заалт *“Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.”*ыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

- Мөнгөн хөрөнгийн зүй бус зарцуулалт үүсэх
- Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

“Нийслэл-Аудит” ХХК-ийн зөвлөмж

- а/ Үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн 2018 оны зарцуулалтыг төсвийн төлөвлөгөөнд тусгуулж батлуулах асуудлыг шийдвэрлүүлэх, гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу тайлагнаж байх
- 2017 оны жилийн эцсийн зарцуулагдаагүй тэтгэврийн 30 хувийн орлогын үлдэгдэл 53,534.6 мянган төгрөгийг байгууллагын Төрийн сангийн харилцах дансанд бэлнээр тушаах, хойшид уг орлогын кассын үлдэгдлийг ямар байдлаар байршуулах талаар холбогдох шийдвэрийг дээд байгууллагаар гаргуулах

Үйлчлүүлэгчийн хариу

- Кассын үлдэгдлийг төвлөрүүлнэ.
- Тэтгэврийн 30 хувийн орлогын

01

зарцуулалтыг төсвийн  
Төрийн Аудитын Байгууллага  
төлөвлөгөөнд тусгуулах  
асуудлыг шийдвэрлүүлнэ.

**ХЯЗГААРДАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

“Нийслэл-Аудит” ХХК-ийн ажиглалт

Өөрийн туслах аж ахуйгаас хүлээж авсан хүнсний ногоо, сүү зэрэг бүтээгдхүүнийг зөвхөн үйлчлүүлэгчдийн хүнсэнд зарцуулсан хэмжээгээр нь орлогод авч мөн хэмжээгээр зарцуулалтыг бүртгэж байгаагаас туслах аж ахуйн орлого санхүүгийн тайланд бүрэн тусгагдахгүй, зарцуулалтанд хяналт тавих боломжгүй байна. Энэ нь УСНББОУС-12 ын 29 дүгээр заалт:” ... Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс бүрдсэн бараа материалыг байгууллага бодит үнэ цэнээс хүлээн авалтын зардлыг хассан дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө” ыг зөрчсөн байна.

Мөн энэ нь Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2 дугаар зүйлийн 2.3 заалт:”*Орлогыг анх хүлээн авсан буюу авлага болгон тооцсон дүнгээр хэмжисж тодорхойлно.* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх заалт “.... *байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*” гэсэн заалтыг зөрчиж байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх  
Бараа материал хяналтгүйгээр зүй бусаар зарцуулагдах

“Нийслэл-Аудит” ХХК-ийн зөвлөмж

Туслах аж ахуйгаас хүлээн авч байгаа бүтээгдхүүнийг тухай бүр орлогоор бүртгэн авч бодит зарцуулалтаар нь зарлагдаж байх, туслах аж ахуйн хүнсний бүтээгдхүүний хорогдлын хувийг тооцох

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг мөрдөж ажиллана

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл   |
|--|------------------|-------------------|
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>             | 396,269,674.8    | 646,483,734.59    |
| <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                      |                  | 53,534,469.0      |
| Кассанд байгаа бэлэн мөнгө                 |                  | 53,534,469.0      |
| Төгрөг                                     |                  | 53,534,469.0      |
| <b>АВЛАГА</b>                              | 2,643,007.9      |                   |
| Ажиллагчидтай холбогдсон авлага            | 2,643,007.9      |                   |
| <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                      | 393,626,666.9    | 529,949,085.59    |
| Түүхий эд материал                         | 22,326,646.5     | 20,120,068.01     |
| Эм боох материал                           | 22,326,646.5     | 20,120,068.01     |
| Хангамжийн материал                        | 295,144,410.4    | 479,423,407.58    |
| Аж ахуйн материал                          | 144,246,397.0    | 227,495,382.0     |
| Түлш, шатах тослох материал                | 2,973,800.0      | 3,385,307.0       |
| Хүнсний материал                           | 78,370,813.4     | 162,809,718.58    |
| Бусад хангамжийн материал                  | 69,553,400.0     | 85,733,000.0      |
| Мал амьтад                                 | 76,155,610.0     | 93,405,610.0      |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>         | 10,065,223,165.7 | 10,211,168,410.16 |
| <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                      | 10,065,223,165.7 | 10,211,168,410.16 |
| Биет хөрөнгө                               | 10,064,453,165.7 | 10,210,590,910.20 |
| Барилга, байгууламж, орон сууц             | 10,656,718,255.0 | 10,656,718,255.0  |
| Хуримтлагдсан элэгдэл                      | -929,123,351.0   | -1,120,759,595.24 |
| Авто-тээврийн хэрэгсэл                     | 208,598,764.0    | 208,598,764.0     |
| Хуримтлагдсан элэгдэл                      | -70,569,610.0    | -105,538,737.12   |
| Машин тоног төхөөрөмж/компьютер/           | 205,050,262.7    | 641,659,473.20    |
